



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 5/19

Хэрлэнбаян-Улаан тосгон

О.Амаржаргалыг ажилд томилох тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 67 дугаар зүйлийн 67.5, “Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 47 дугаар зүйлийн 47.1, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, дээд хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 05 сарын 02-ны 26 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Оюунчимэгийн Амаржаргалыг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс Захирагчийн ажлын албаны жолоочоор томилсугай.
2. Жолооч О.Амаржаргалын үндсэн цалинг ТҮ-3 буюу 1052000 төгрөгөөр тогтоож, орон нутгийн нэмэгдэл 60%-иар нэмж цалинжуулахыг нягтлан бодогч (Ю.Батбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (А.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ОТГОНБАЯР

